



БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2016 оны 11 сарын 10-ны
өдрийн 180 дугаарт бүртгэв.

2016 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 180

Улаанбаатар хот

Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх
журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.18 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Барилга байгууламжийн хувийн хэрэг"-ийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Барилга байгууламжийн хувийн хэрэг, түүнийг хөтлөх журмыг мөрдөж ажиллахыг барилга байгууламжийн өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нарт, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Барилга байгууламжийн хувийн хэрэг, түүнийг хөтлөх журмыг хэвлэн олшруулах, холбогдох байгууллагад хүргүүлж мөрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Занабазар/-т үүрэг болгосугай.


4. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 71 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  Д. МӨНХБАЯР



08 00577

Барилга, хот байгуулалтын сайдын
2016 оны 11 дугаар сарын 17-ны өдрийн
180 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХУВИЙН ХЭРЭГ ХӨТЛӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь барилга байгууламжийн талаарх мэдээллээр хэрэглэгч, худалдан авагч, түрээслэгчийг хангах, барилга байгууламжийн хувийн хэрэгт байх зүйлсийн бүрдүүлбэрийг тогтоох, эдэлгээний хугацаанд тухайн барилга байгууламжид хийгдсэн өргөтгөл, өөрчлөлт, шинэчлэл, их засвар, үзлэг шалгалт, түүнд гарсан эвдрэл, гэмтэл, согогыг бүртгэж, барилга байгууламжийн хувийн хэргийг хөтлөхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Барилгын тухай хуулийн 4.1.1-д заасан "барилга байгууламж" гэсэн тодорхойлолтод хамаарагдах, Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдсан, бүх төрлийн барилга байгууламжийн /гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын иргэдийн өмчийн болон тэдний мэдлийнхээс бусад/ хувийн хэргийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр заавал хөтөлнө.

1.3. Барилга байгууламжийн хувийн хэрэг нь тухайн барилга байгууламжийн эдэлгээний хугацаанд хийгдсэн өргөтгөл, өөрчлөлт, шинэчлэл, их засварын ажил, үзлэг шалгалт, гарсан эвдрэл, гэмтэл, согогын талаарх мэдээлэл, уг барилга байгууламжийн үндсэн үзүүлэлтийг агуулсан баримт бичиг байна.

1.4. Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөхөд Барилгын тухай, Орон сууцны тухай хууль, энэхүү журам болон холбогдох бусад эрх зүйн актуудыг мөрдөнө.

1.5. Иргэний хуулийн 89-90 дүгээр зүйлд заасан этгээд нь барилга байгууламжийн эзэмшигч, 100 дугаар зүйлд заасан этгээд нь барилга байгууламжийн өмчлөгч байна.

1.6. Өмчлөгч, эзэмшигч нь барилга байгууламжийг ашиглалтад орох үед барилга байгууламжийн хувийн хэргийг нээж, түүнд энэ журамд заасны дагуу хувийн хэрэг, холбогдох хавсралт материалууд болон барилга байгууламжийн баримт бичгийг бүрдүүлэн хөтөлж барилга байгууламжийн эдэлгээний хугацаанд хадгална.

1.7. Барилгын тухай хуулийн 32.1.6-д заасны дагуу Засгийн газраас баталсан "Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм"-д нийцүүлж, энэ журмын дагуу барилга байгууламжийн хувийн хэргийг баяжуулж, хадгалах үүргийг тухайн барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигч хүлээнэ.

1.8. Өмчлөгч, эзэмшигч нь хувийн хэрэг хөтлөгдөж байгаагүй хуучин барилга байгууламжид тусгай зөвшөөрөл бүхий зураг төслийн байгууллагатай гэрээ байгуулан холбогдох үзүүлэлтийг дахин тооцуулах, мэргэжлийн дүгнэлт гаргуулах, хэмжилтийн зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгүүлж, түүнийг үндэслэн хувийн хэргийг нөхөн хөтөлж, баяжуулалт хийнэ.

Хоёр. Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх үйл ажиллагаа

2.1. Өмчлөгч, эзэмшигч нь барилга байгууламжийг ашиглалтад орох үед түүний хувийн хэргийг нээж хөтлөн эдэлгээний хугацаанд түүнд өргөтгөл, шинэчлэл, их засвар, үзлэг, шалгалт хийсэн, зориулалтыг өөрчилсөн, эвдрэл, гэмтэл, согог гарсан, сервитут тогтоосон, буулгасан тохиолдолд хувийн хэрэгт баяжуулалт хийнэ.

2.2. Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180-р тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Барилга байгууламжийн хувийн хэрэг"-т заасан доорх бүрдэл хэсгээр хувийн хэргийг хөтлөх бөгөөд түүнд заасан холбогдох үзүүлэлтүүдийг барилга байгууламж нэг бүрд тодорхойлж тэмдэглэнэ. Үүнд:

- 2.2.1. барилга байгууламжийн үндсэн мэдээлэл;
- 2.2.2. барилга байгууламжид хийсэн үзлэг, шалгалтын тэмдэглэл;
- 2.2.3. барилга байгууламжид хийсэн их засвар, өргөтгөл, өөрчлөлт, шинэчлэлийн талаарх тэмдэглэл;
- 2.2.4. барилга байгууламжийн дахин үнэлгээ;
- 2.2.5 ашиглалтын явцад гарсан эвдрэл, гэмтэл, согогийн тухай тэмдэглэл;

2.2.6. барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөлтийн байдал;

2.2.7. барилга байгууламжийн холбогдолтой баримт бичгийн жагсаалт.

2.3. Өмчлөгч, эзэмшигч нь барилга байгууламжийн хувийн хэргийг хөтлөхдөө дараах зарчим, дарааллыг баримтална. Үүнд:

2.3.1. Барилга байгууламжийг ашиглалтад анх хүлээж авахдаа түүний талаарх үндсэн мэдээлэл, зураг төсөлд заагдсан бусад өгөгдлүүдийг захиалагч байгууллагаар хувийн хэрэгт нь бичүүлж, түүний үнэн зөвийг нягталж шалгана.

2.3.2. Хуучин барилга байгууламжийн хувийн хэргийг нөхөж хөтлөхдөө тухайн барилга байгууламжийн батлагдсан зураг төсөл, холбогдох акт баримт, дүгнэлтийг үндэслэнэ. Хэрвээ газар хөдлөлтийг тэсвэрлэх арга хэмжээ зураг төсөлд нь тусгагдаагүй байвал тусгай зөвшөөрөл бүхий зураг төслийн байгууллагатай гэрээ байгуулан барилга байгууламж, түүний хийц бүтээцийн чанар байдлыг шалгуулж, дүгнэлт гаргуулан газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг тогтоолгож, түүнийг үндэслэн холбогдох үзүүлэлтийг хувийн хэрэгт тодорхой тэмдэглэнэ.

2.3.3. Барилга байгууламжийн эдэлгээний хугацаанд хийгдэх үзлэг, шалгалтыг "Барилга, байгууламжийн ашиглалтын дүрэм", "Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм"-д заасны дагуу гүйцэтгэж, хийгдсэн үзлэг, шалгалтын талаарх дүгнэлт, дэлгэрэнгүй материалыг холбогдох мэдээллийн хамт хувийн хэрэгт тэмдэглэж, хадгална. Түүнчлэн барилгын үндсэн хийц бүрд гүйцэтгэсэн үзлэг, хийц бүтээцийн чанар байдалд өгсөн үнэлгээний талаар бичиж тэмдэглэнэ.

2.3.4. Барилгын улсын хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, улсын байцаагчаас өгсөн албан шаардлага, дүгнэлт, түүний дагуу авсан арга хэмжээ, түүнчлэн барилга байгууламжид хамгаалалтын горим, сервитут тогтоосон, чанар аюулгүй байдлын түвшингээр паспортжуулж, ашиглалтын гэрчилгээ олгосон, эдэлгээний хугацаа дууссан үед цаашид ашиглахаар шийдвэрлэсэнтэй холбоотой бусад мэдээлэл, шийдвэрийн талаар тодорхой бичиж тэмдэглэнэ.

2.3.5. Барилга байгууламжийн их засвар, өргөтгөл, өөрчлөлт, шинэчлэлтийн боловсруулагдсан зураг төсөл, барилгын ажлын гүйцэтгэл, түүнд зарцуулсан хөрөнгө, чанар байдлын тухай хувийн хэрэгт бичиж, ил далд ажлын

акт зэрэг холбогдолтой бичиг баримтыг хувийн хэргийн хавтаст хийж, баримт бичгийн жагсаалтад бүртгэнэ.

2.3.6. Барилга байгууламжид гэнэтийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйлсийн /газар хөдлөлт, гал түймэр, үер ус, хүчтэй салхи, шуурга гэх мэт/ улмаас ашиглалтын хугацаанд гарсан эвдрэл, гэмтэл согог, түүнээс шалтгаалан ашиглалтгүй байсан хугацаа, түүнийг хэрхэн зассан, тэдгээрийн огноог бичиж тэмдэглэнэ. Засаж сайжруулсан, хүчитгэсэн, бэхэлсэн ажлын зураг төслийг хувийн хэрэгт хавсаргаж хадгална.

2.3.7. Барилга байгууламжид дахин үнэлгээ хийсэн байгууллагаас гаргасан шийдвэрийн огноо, дугаар, хийсэн үнэлгээний талаархи мэдээллийг бичиж, үнэлгээний тайланг хувийн хэрэгт хавсаргаж хадгална.

Гурав. Бусад

3.1. Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигч нь энэ журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

-----oO-----

Барилга, хот байгуулалтын сайдын
2016 оны 11 дугаар сарын 10-ны өдрийн
180 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХУВИЙН ХЭРЭГ

I-р хэсэг. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

1. Барилга байгууламжийн эрхийн улсын бүртгэлийн дугаар

2. Барилга байгууламжийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний
регистрийн дугаар

3. Барилга байгууламжийн байршил /Аймаг, хот, сум, дүүрэг, баг, хороо/

4. Барилга байгууламжийн нэр, төвөгшлийн зэрэг

5. Өмчлөгч, эзэмшигч /доогуур зурах/-ийн нэр

6. Барилгын зориулалт, хүчин чадал:

а/ Орон сууцны барилга /айлын тоогоор/

б/ Албан контор, захиргааны барилга

в/ Үйлчилгээ, олон нийтийн барилга

г/ Үйлдвэрийн барилга

д/ Авто зам / төрлөөр нь /

е/ Шугам сүлжээ /дулаан, цэвэр, бохир ус/

7. Инженерийн байгууламжийн зориулалт

8. Инженерийн байгууламжийн хүчин чадал

9. Барилгажилтын талбай /м2/

10. Нийт талбай /м2/

11. Ажлын /ашигтай/ талбай /м2/

12. Барилга байгууламжийн галд тэсвэрлэлтийн зэрэг

13. Барилга байгууламжийн зүгшрүүлэх, тохируулах, хэвийн ашиглалтын болон эдэлгээний хугацаа

14. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээний хангалт

15. Зураг төсөл зохиосон огноо

16. Зураг төсөл зохиосон аж ахуйн нэгжийн нэр

17. Зураг төсөл зохиосон аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар

18. Зургийн шифр дугаар

19. Газар олгосон, эзэмшүүлсэн байгууллагын нэр, шийдвэрийн огноо, дугаар

20. Хөрөнгө оруулалтын хэмжээ, түүний эх үүсвэр /сая төгрөгөөр/:

а/ Улсын төсөв

б/ Монгол улсыг хөгжүүлэх сан

в/ Гадаадын зээл, тусламж

г/ Хувийн хөрөнгө

д/ Олон нийтийн байгууллагын хөрөнгө

е/ Өмчийн холимог хэлбэр

21. Ашиглалтанд орсон огноо

22. Барилгын ажлыг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар

23. Инженерийн хангамжийн систем, түүний ашиглалтын үзүүлэлтүүд

1. Дулааны хэрэгцээ:

Бүгд (ккал/цаг)

Үүнээс:

а. Халаалт (ккал/цаг)

б. Халуун ус (ккал/цаг)

в. Салхивч (ккал/цаг)

Дулаан хангамжийн системийн тухай мэдээлэл:

Агаар сэлгэлтийн системийн тухай мэдээлэл:

2. Усны хэрэгцээ:

Бүгд (м3/хоног, л/сек)

Үүнээс:

а. Халуун ус (м3/хоног, л/сек)

б. Хүйтэн ус (м3/хоног, л/сек)

в. Галын ус (м3/хоног, л/сек)

г. Бохир ус (м3/хоног, л/сек)

д. Даралт /м/

Ус хангамжийн системийн тухай мэдээлэл:

Ариутгах татуургын системийн тухай мэдээлэл:

3. Цахилгааны хэрэгцээ:

Бүгд (кВт/хоног, А/сек)

Үүнээс:

а. Суурилагдсан /кВт/

б. Тооцооны /кВт/

в. Гүйдэл / А/

Цахилгаан хангамжийн системийн тухай мэдээлэл:

4. Хийн хэрэгцээ:

Хийн хангамжийн системийн тухай мэдээлэл:

5. Холбоо, дохиолол:

Холбоо, дохиоллын системийн тухай мэдээлэл:

6. Галын дохиолол:

Галын дохиоллын системийн тухай мэдээлэл:

7. Лифт:

а. ачааны /марк, даац/

б. хүн зөөврийн /марк, даац/

24. Эдэлбэр газар

1. Өндөржилт

2. Нийт эзэмшлийн талбай /м2/

Үүнээс:

а. Барилгажсан талбай / м2/

б. Зүлэгжүүлсэн талбай /м2/

в. Хатуу хучилттай талбай /м2/

г. Байгалийн төрхөөрөө байгаа талбай /м2/

д. Модны тоо /ш/

е. Бут, сөөгний тоо /ш/

ё. Гэрэлтүүлгийн тоо /ш/

25. Барилга байгууламжид хамгаалалтын горим , сервитут тогтоосон болон ашиглалтгүй байсан хугацаа /эхэлсэн, дууссан огноо, үргэлжилсэн хугацаа жил, сараар/

26. Барилга байгууламжийн газар хөдлөлтийн мэдээлэл

1. Барилгын өндөр /м/

2. Барилгын урт /м/

3. Барилгын өргөн /м/

4. Давхрын тоо

5. Зоорийн давхрын тоо

6. Эзлэхүүн төлөвлөлтийн шийдэл :

а/ Тэгш өнцөгт хэлбэртэй

б/ "Г" хэлбэртэй

в/ "Т" хэлбэртэй

г/ "П" хэлбэртэй

д/ Дугуй хэлбэртэй

е/ Бусад

7. Барилгын суурийн шийдэл :

а/ Чулуут бетон дүүргэгчтэй шугаман

б/ Бетонон

в/ Төмөр бетон баганан

г/ Төмөр бетон хавтан /хавтгай/

д/ Төмөр бетон огтлолцсон шугаман

е/ Гадсан

8. Барилгын даацын үндсэн бүтээц :

а/ Тоосгон өрөг даацын хана

б/ Төмөр бетон араг бүтээц

в/ Ган араг бүтээц

г/ Гулсах хэв ашигласан цутгамал
төмөр бетон даацын хана

д/ Зөөврийн эзэлхүүнт ба бамбайт хэв ашигласан
цутгамал бетон даацын хана

е/ Том хавтгаалжин барилга

ё/ Тоосгон өрлөгтэй даацын хана ба
дотор араг бүтээц

ж/ Хөшүүний цөм ба араг бүтээцэн барилга

з/ Хөшүүний диафрагмтай араг бүтээц _____

и/ Ган босоо холбоостой араг бүтээц

9. Хучилтын хийц :

а/ Угсармал, төмөр бетон хавтан

б/ Цутгамал төмөр бетон

в/ Модон

г/ Угсармал, цутгамал хослосон

10. Дээврийн хучлагын төрөл :

а/ Хуйлмал

б/ Цардмал

в/ Вааран хавтан

- г/ Нимгэн гөлмөн төмөр _____
- д/ Хэвлэсэн төмөр _____
- е/ Металл хавтан _____
- ё/ Полимер хавтанцар _____
- ж / Ховилт төмөр бетон хавтан _____

11. Дээврийн хучилтын даацын хийц :

- а/ Төмөр бетон дам нуруу _____
- б/ Төмөр бетон татанга _____
- в/ Ган дам нуруу _____
- г/ Ган татанга _____
- д/ Модон дам нуруу _____
- е/ Модон татанга _____
- ё/ Шувуу нуруу _____

12. Ханын хашлага хийц:

- а/ Өлгөмөл керамзит бетон хавтгаалж _____
- б/ Өлгөмөл төмөр бетон хавтгаалж _____
- в/ Өлгөмөл хөнгөн хавтгаалж "сэндвич" маягийн _____
- г/ Тоосгон өрлөгтэй өөрийгөө даах хана _____
- д/ Мөн адил, төмөр бетон хавтгаалжин _____
- е/ Хөнгөн бетон, эрдэс бетон, бусад гулдмайн өрлөгтэй дүүргэгч хана _____

13. Хамар хана:

- а/ Тоосгон өрөг _____
- б/ Модон араг ястай гипсэн хавтан _____
- в/ Төмөр араг ястай гипсэн хавтан _____

г/ Том хэмжээтэй гипс бетонон хавтан _____

д/ Төмөр бетон _____

е/ Шилэн блок _____

ё/ Модон _____

14. Газар хөдлөлтийн заадастай эсэх:

а/ Заадастай _____

б/ Заадасгүй _____

15. Барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэх зэрэг _____

16. Барилга байгууламжийн талбайн газар хөдлөлтийн идэвхжил (баллаар)

а/ 7 балл _____

б/ 8 балл _____

в/ 9 балл _____

г/ 10 балл _____

д/ Идэвхжилгүй _____

17. Буурь хөрс:

Буурь хөрсний үзүүлэлт, шинж чанар:

Буурь хөрсийг газар хөдлөлтийн шинж чанараар ангилсан хөрсний зэрэглэл _____

Тайлбар:

1. Барилга байгууламжийн нэр, зориулалт, төвөгшил, барилгын өндөр, урт, өргөн, давхрын тоо, зоорийн давхрын тоо, инженерийн хангамж, түүний ашиглалтын үзүүлэлтүүд, гал тэсвэрлэлтийн зэрэг, эдэлгээний зэрэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээний хангалт, эдэлбэр газрын талаарх мэдээллүүдийг барилга байгууламжийн зураг төсөлд тусгагдсанаар бичнэ.

2. Зураг төсөл боловсруулсан, барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн нэрийг ерөнхий гүйцэтгэгчээр бичнэ.

3. "Газар олгосон, эзэмшүүлсэн шийдвэрийн огноо, дугаар" гэсэн хэсэгт газар олгосон, кадастрын зураг хийсэн байгууллагын нэр, шийдвэрийн огноо, дугаарыг бичиж, олгогдсон газрын кадастрын зураглалын захын цэгүүдийн координатуудыг бичиж тэмдэглэнэ

4. Барилгын буурь хөрсний үзүүлэлт, шинж чанар, талбайн газар хөдлөлтийн идэвхжилийг барилгын талбайд хийсэн инженер-хайгуулын судалгааны дүгнэлт, талбайн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг үндэслэн бичнэ.

o

2-р хэсэг.

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ХИЙСЭН ҮЗЛЭГ,
ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ**

№	Үзлэг, шалгалт хийсэн огноо	Барилга байгууламжид хийгдсэн үзлэг, шалгалт, илэрсэн зөрчил дутагдлын тухай	Үзлэг, шалгалт хийх комиссыг томилсон тушаалын дугаар, огноо	Үзлэг, шалгалт хийсэн комиссын дүгнэлтийн дугаар	Хуудасны тоо
1	2	3	4	5	6

ТАЙЛБАР:

1. "Барилгын ашиглалтын дүрэм", "Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм"-д заасны дагуу гүйцэтгэсэн үзлэг, шалгалтын тухай тэмдэглэж, дэлгэрэнгүй материалыг хувийн хэргийн хавтаст хийж хадгална.
2. Барилгын үндсэн хийц тус бүрт явуулсан үзлэгийн талаар болон хийц бүтээцийн чанар байдалд өгсөн үнэлгээг хувийн хэрэгт тэмдэглэнэ.
3. Барилга байгууламжийн чанар байдлыг барилгын техникийн хяналтыг хэрэгжүүлэгч, мэргэжлийн болон хууль, хяналтын байгууллага, улсын байцаагчаас шалгаад өгсөн үнэлэлт, дүгнэлт, шаардлагын талаар тодорхой бичиж тэмдэглэнэ.

3-р хэсэг. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ХИЙСЭН ИХ ЗАСВАР, ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААРХ ТЭМДЭГЛЭЛ

ДД	Их засвар, өргөтгөл, шинэчлэл хийсэн, зориулалт, үндсэн хийцийг өөрчилсөн байдал. огноо	Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр	Барилгын ажлыг гүйцэтгэгч байгууллагын нэр	Техникийн дүгнэлт гаргасан байгууллагын нэр	Хүлээн авсан комиссын актын дугаар, огноо	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/
0	1	2	3	4	5	6
1	Их засварын талаар					
2	Өргөтгөлийн талаар					
3	Шинэчлэл хийсэн					
4	Үндсэн хийцийг өөрчилсөн					
5	Зориулалтыг өөрчилсөн, бусад					

ТАЙЛБАР:

1. Барилга, байгууламжид хийсэн их засвар, өргөтгөл, шинэчлэлийг төрөл тус бүрээр нь техникийн дүгнэлт гаргасан, зураг төслийг боловсруулсан, угсралтын ажлыг гүйцэтгэсэн байгууллагын нэр, ажлыг хүлээж авсан акт, зарцуулсан хөрөнгө, чанар байдлын тухай бичиж тэмдэглэж, бусад холбогдолтой бичиг баримтыг хувийн хэргийн хавтаст хийж хадгална.

2. Барилгын үндсэн бүтээцэд өөрчлөлт оруулсан, зориулалтыг өөрчилсөн болон инженерийн шугам сүлжээний зарим хэсгийг буюу бүхэлд нь сольж, шинэчилсэн бол түүний зураг төсөл, ажлын гүйцэтгэл, зарцуулсан хөрөнгө, түүний чанар байдлын талаар тэмдэглэнэ.

4-р хэсэг. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭ

Анхны өртөг /сая.төг/

№	Дахин үнэлгээ хийх шийдвэрийн огноо, дугаар	Дахин үнэлгээ хийсэн байгууллагын нэр, үнэлгээний тайлангийн огноо, дугаар	Дахин үнэлгээгээр тодорхойлсон барилгын үнэ	Үнэлгээний өсөлт, бууралтын хувь	Тайлбар
1	2	3	4	5	6

ТАЙЛБАР :

1. Барилга байгууламжинд дахин үнэлгээ хийх шийдвэр, хийгдсэн дахин үнэлгээний дүн, анхны өртөгтэй харьцуулсан өсөлт бууралтын хувь, үнэлгээг баталгаажуулсан байгууллагын нэр, үнэлгээний тайлангийн огноо, дугаар, түүний талаархи мэдээллийг тэмдэглэж дахин үнэлгээний тайланг хувийн хэргийн хавтаст хийж хадгална.

5-р хэсэг. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ГАРСАН ЭВДРЭЛ,
ГЭМТЭЛ, СОГОГЫН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

ДД	Эвдрэл гэмтэл, согог гарсан шалтгаан	Эвдрэл, гэмтэл, согог гарсан огноо	Үзлэг хийсэн огноо	Учирсан эвдрэл, гэмтэл, согогын төрөл	Засвар- ласан огноо	Эвдрэл гэмтэл, согогыг хэрхэн арилгасан тухай тэмдэглэгээ /хүчитгэсэн, бэхэлсэн г.м/
1	Газар хөдлөлтөөс					
2	Гал түймэрээс					
3	Үер уснаас					
4	Хүчтэй салхи шуургаас					
5	Хөлдөлтөөс					
6	Бусад шалтгаанаас					

Гарсан эвдрэл, гэмтэл, согог болон бусад зүйлсийн талаарх тэмдэглэл.

**6-р хэсэг. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХУВИЙН
ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН БАЙДАЛ**

№	Хувийн хэрэг хөтөлсөн, баяжуулалт хийсэн тухай тэмдэглэл	Хувийн хэрэг хөтөлсөн хүний		Огноо	Гарын үсэг
		Албан тушаал	Овог, нэр		
1	2	3	4	5	6

ТАЙЛБАР : 1. Барилга, байгууламжийн хувийн хэргийн хөтлөлтийн талаарх мэдээллийг тухайн барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчээс томилсон хүн тухай бүр тэмдэглэж хөтөлнө.

**7-р хэсэг. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХОЛБОГДОЛТОЙ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн нэр	Баримт бичгийн үндэслэл / захирамж, тушаал, шийдвэр, дүгнэлт, актын нэр огноо, дугаар/	Хуудасны тоо	Баримт бичгийг хаана хадгалж байгаа тухай тайлбар
0	А	Б	В	Г
1	Барилга, байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар хувь			
2	1. Газар олголтын захирамж 2. Зургийн даалгавар 3. Ариун цэврийн хяналтын зөвшөөрөл 4. Галын аюулгүй байдлын хяналтын зөвшөөрөл Техникийн нөхцлүүд: 1. Дулаан хангамж 2. Ус хангамж 3. Цахилгаан хангамж 4. Холбоо Бусад 1. Байгаль орчны үнэлгээ 2. Барилга барих газрын нэгж талбарын кадастрын зураг			
3	Инженер геологийн судалгаа, хайгуулын ажлын дүгнэлт			
4	Барилга байгууламжийн зураг төсөл 1. Ерөнхий төлөвлөгөө, өндөржилт, тохижилт 2. Барилга архитектур 3. Барилга бүтээц 4. Халаалт, салхивч 5. Цэвэр бохир ус 6. Цахилгаан 7. Холбоо, галын дохиолол 8. Радио 9. Технологи 10. Гадна шугам сүлжээ 11. Барилгын ажлын талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөл 12. Байр зүйн дэвсгэр зураг 13. Гүйцэтгэлийн зураг төсөл 14. Бусад			
5	Захилагчийг томилсон, өөрчилсөн			

	шийдвэр, Захиалагчийн байгуулсан гэрээ, гэрээний дүгнэлт зэрэг захилагчтай холбоотой баримт бичгүүдийн хуулбар хувь			
6	Тэг тэнхлэг тавьсан акт			
7	Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл			
8	Барилгын ил, далд ажлын баталгаажуулсан актууд , баримтжуулсан фото зураг			
9	Барилга, байгууламжийг барих буюу ашиглах явцад зохиогч болон барилгын техник байгаль орчин, эрүүл ахуй, галын зэрэг хяналтын албанаас өгсөн дүгнэлт, шаардлагын хуулбар хувь			
10	Угсралтын явцад гарсан алдаа зөрчлүүд			
11	Барилга байгууламжид хамгаалалтын горим тогтоосон шийдвэрийн хуулбар хувь			
12	Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан акт болон зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт, захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлтийн хуулбар хувь			
	Барилга байгууламжийн төвөгшлийн ангилал/зэрэг/ тогтоосон, паспорт-жуулсан, ашиглалтын гэрчилгээ олгосон шийдвэрийн хуулбар хувь			
13	Барилга байгууламжийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар хувь			
14	Ашиглалтын хугацаанд хийгдсэн үзлэг, шалгалтын талаарх дэлгэрэнгүй материала-лууд			
15	Барилга, байгууламжид хийсэн их засвар, өргөтгөл, шинэчлэлийн зураг төсөл, гарсан эвдрэл, гэмтэл, согогыг засаж бэхэлгээ, хүчитгэл хийсэн зураг төсөл, тэдгээрийг ашиглалтад хүлээж авсан акт, баримтууд			
16	Барилга байгууламжийн дахин үнэлгээний тайлан			
17.	Ашиглалтын хугацаанд гарсан эвдрэл, гэмтэл, согог, зөрчлийн жагсаалт, холбогдох дүгнэлт, акт баримтууд			

	Барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээц, материалд оруулсан өөрчлөлт, даацын бат бэхийг лабораторийн шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулсан баталгаажуулалтын хуулбар хувь			
18.	Барилга байгууламжид сервитут тогтоосон шийдвэрийн хуулбар хувь			
19	Эдэлгээний хугацаа дууссан үед цаашид ашиглахаар шийдсэн шийдвэрийн хуулбар хувь			
	Барилга байгууламжийг албадан буулгах шийдвэрийн хуулбар хувь			

ТАЙЛБАР:

1. Өмчлөгч, эзэмшигч нь барилга, байгууламжтай холбогдолтой бичиг баримтын жагсаалтын дагуу бүх бичиг баримтыг бүрдүүлж, түүнийг баталсан захирамж, тушаал, акт, дүгнэлтийн дугаар огноо, хуудасны тоо, уг баримт бичиг хаана хадгалж байгаа тухай тэмдэглэж тэдгээрийн хуулбарыг хувийн хэргийн хавтаст хийж хадгалана

oOo

“Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам”, “Барилга байгууламжийн хувийн хэрэг”-ийн нөлөөллийн шинжилгээ

1. Акт гаргах үндэслэл, шаардлага, зорилтыг тодорхойлох.

(Захиргааны байгууллагад Захиргааны ерөнхий хуулийн 59.1 дэх хэсэгт заасны дагуу хуулиар тусгайлан эрх олгогдсон байх нь акт гаргах үндэслэл болно. Тухайн шийдвэрийг хэрэгжүүлснээр тавьсан зорилгод хүрч чадах эсэхийг тогтооно. Зорилт нь тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байхаас гадна аль болох тодорхой, хэмжих боломжтой, бодитой байдлаар томъёологдсон байна.)

“Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1. 18-д зааснаар Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар хуульчилсан. “Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам”, “Барилга байгууламжийн хувийн хэрэг” батлагдснаар барилга байгууламжийн талаарх мэдээллээр хэрэглэгч, худалдан авагч, түрээслэгчийг хангах, барилга байгууламжийн хувийн хэргийн бүрдүүлбэрийг тогтоох, эдэлгээний хугацаанд тухайн барилга байгууламжид хийгдсэн өргөтгөл, шинэчлэл, их засвар, үзлэг шалгалт, түүнд гарсан эвдрэл, гэмтэл, согогыг бүртгэж, барилга байгууламжийн хувийн хэргийг хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

2. Тухайн актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ.

(Энэ хэсэгт тухайн актаар зохицуулах асуудлын хүрээг тодорхой заана. Зохицуулах харилцааны хүрээ, хэмжээг тодорхой заана. Зохицуулах асуудлын хүрээг дутуу зааснаас практикт зохицуулалтгүй асуудал үлдэж, хариуцах эзэнгүй болдог. Акт нь бүтцийн хувьд гарчиг, тэмдэглэх хэсэг, тогтоох хэсэг, шаардлагатай бол урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болгох тухай хэсэг болон акт хүчин төгөлдөр болох хугацааг тус тусгана.)

Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам нь нийтлэг үндэслэл ; барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх үйл ажиллагаа ; Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчид хүлээлгэх хариуцлага гэсэн үндсэн 3 бүлэг, 18 заалттай боловсруулагдсан.

Барилга байгууламжийг шинээр ашиглалтад орох үед өмчлөгч, эзэмшигч нь барилга байгууламжийн хувийн хэргийг нээж, түүнд холбогдох хавсралт материалууд болон барилга байгууламжийн баримт бичгийг бүрдүүлэн хөтөлж, барилга байгууламжийн эдэлгээний хугацаанд түүнд өргөтгөл, шинэчлэл, их засвар, үзлэг, шалгалт хийсэн, зориулалтыг өөрчилсөн, эвдрэл, гэмтэл, согог гарсан, сервитут, хамгаалалтын горим тогтоосон, буулгасан тохиолдолд энэ талаар хувийн хэрэгт бичиж, холбогдох материалыг бүрдүүлж хадгална.

Энэ хүрээнд зохицуулалтгүй асуудал гаргахгүй тулд Хувийн хэрэг хөтлөгдөж байгаагүй хуучин барилга байгууламжид тусгай зөвшөөрөл бүхий зураг төслийн байгууллагатай гэрээ байгуулан холбогдох үзүүлэлтийг дахин тооцуулах, мэргэжлийн дүгнэлт гаргуулах, хэмжилтийн зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгүүлж, түүнийг үндэслэн хувийн хэргийг өмчлөгч, эзэмшигч нь нөхөн хөтөлж, баяжуулалт хийхээр тусгасан.

“Барилга байгууламжийн хувийн хэрэг”-ийг доорх бүрдэл хэсгээр хөтлөх бөгөөд түүнд заасан холбогдох үзүүлэлтүүдийг барилга байгууламж нэг бүрд тодорхойлж тэмдэглэнэ. Үүнд:

1. Барилга байгууламжийн үндсэн мэдээлэл
2. Барилга байгууламжид хийсэн үзлэг, шалгалтын тэмдэглэл
3. Барилга байгууламжид хийсэн их засвар, өргөтгөл, шинэчлэлийн талаарх тэмдэглэл
4. Барилга байгууламжийн дахин үнэлгээ
5. Ашиглалтын явцад гарсан эвдрэл, гэмтэл, согогийн тухай тэмдэглэл
6. Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөлтийн байдал
7. Барилга байгууламжийн холбогдолтой баримт бичгийн жагсаалт

3. Акт батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийг тодорхойлох. (Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасан журмын дагуу жиллагаа явуулна.)

Акт батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлэг байхгүй.

4. Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх.

(-Хүний эрх, эрх чөлөө ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх;

-Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарласан бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх;

-Жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;

-Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх;

-Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх;

-Зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгох эсэх;

-Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагад захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болгож байгаа эсэх;

-Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоход хүргэх эсэх

-Бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх;

-Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх.)

Энэ журамд хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн зохицуулалт байхгүй.

“Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам”, “Барилга байгууламжийн хувийн хэрэг”-ийг шинэчилснээр эзэмшигч, өмчлөгч, худалдан авагч, түрээслэгч, үнэлгээчин, шинжээч, хууль хяналтын байгууллагыг тухайн барилга байгууламжийн талаарх мэдээллээр хангах, ашиглалтын явцад барилга байгууламжид эвдрэл гэмтэл учрах, нурах тохиолдолд барилгын ажил гүйцэтгэгч, захиалагч, зураг төсөл зохиогч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутайг нь тогтоож хариуцлага хүлээлгэх талаар холбогдох мэдээллийг хувийн хэргээс ашиглах боломж бүрдэх юм.

5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх. (Тухайн харилцааг урьд нь хууль эрх зүйн бусад актаар зохицуулж байгаа эсэхийг орхигдуулалгүй судлан, эрх зүйн зохицуулалтын давхардлыг үүсгэхээс сэргийлэх арга хэмжээг авна.)

Шинэчлэн батлагдсан "Барилгын тухай" хуулийн нэр томъёо, шаардлага, холбогдох заалтуудад нийцүүлэн "Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам", "Барилга байгууламжийн хувийн хэрэг"-ийн төслийг шинэчлэн боловсруулсан. Ингэснээр Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 71 дүгээр тушаалаар баталсан "Барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл, шинэчлэл, их засварын хувийн хэрэг хөтлөх журам", "Барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл, шинэчлэл, их засварын хувийн хэрэг"-ийг хүчингүй болгоно.

- 6. Актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоог** (шинээр төрийн байгууллага байгуулах, эсвэл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэх, захиргааны шинэ чиг үүрэг бий болгох, шаардлага тавигдах эсэх, мөн тухайн шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдон улсын төсөв болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зардал үүсэх, бууруулах эсэхийг судлах)

Энэ журам, хувийн хэрэг батлагдснаар шинээр төрийн байгууллага байгуулагдахгүй, төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэхгүй, захиргааны шинэ чиг үүрэг бий болохгүй, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон улсын төсөв болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд нэмж зардал үүсэхгүй болно.

- 7. Хүний нөөц, техник, эдийн засгийн тооцооны үнэлгээг тоон хэмжигдэхүүнээр /мөнгөн хэлбэрээр/ илэрхийлэх ба боломжгүй тохиолдолд нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, үр дагаврыг тодорхойлно.**

"Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам", "Барилга байгууламжийн хувийн хэрэг"-ийг шинэчилснээр эзэмшигч, өмчлөгч, худалдан авагч, түрээслэгч, үнэлгээчин, шинжээч, хууль хяналтын байгууллагыг тухайн барилга байгууламжийн талаарх мэдээллээр хангах, ашиглалтын явцад барилга байгууламжид эвдрэл гэмтэл учрах, нурах тохиолдолд холбогдох мэдээллийг хувийн хэргээс тодруулж гүйцэтгэгч, захиалагч, зураг төсөл зохиогч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутайг нь тогтоож, хариуцлага хүлээлгэх боломж бүрдэх юм. Барилга байгууламжийн ашиглалтын явцад эзэмшигч, өмчлөгч хяналт тавьж хувийн хэргийг баяжуулан хөтлөх учир нийгэм, эдийн засагт ямар нэгэн сөрөг үр нөлөө, үр дагавар үүсэхгүй. Харин барилга байгууламжийг зөв зохистой ашигласнаар хүний аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бүрдэнэ.

- 8. Нөлөөллийн шинжилгээг хийсний үр дүнд тухайн шийдвэрийг гаргах зайлшгүй шаардлагатай нь нотлогдсон тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 62.1 дэх хэсэгт заасны дагуу санал авах ба мөн хуулийн 62.2, 62.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу хэлэлцүүлэг зохион байгуулна.**

Журам, хувийн хэргийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, санал авахаар БХБЯамны вэб сайтад нийтлүүлсэн, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

“Барилга байгууламжийн хувийн хэрэг, түүнийг хөтлөх журам”-ын танилцуулга

“Барилгын тухай” хуулийн 4 дүгээр зүйлд “барилга байгууламжийн баримт бичиг”, “барилга байгууламжийг ашиглалтад оруулсан гэрчилгээ”, “барилга байгууламжийн техникийн нөхцөл”, “гүйцэтгэлийн зураг”, “паспортжуулах” гэдэг нэр томъёог тодорхойлж, мөн хуулийн 33.1.18-д “Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам”-ыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар заасан.

“Барилгын тухай” хуулийн нэр томъёо, шаардлага, холбогдох заалтуудад нийцүүлэн “Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам”, “Барилга байгууламжийн хувийн хэрэг”-ийн төслийг шинэчлэн боловсруулсан. Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам нь нийтлэг үндэслэл ; барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх үйл ажиллагаа ; Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчид хүлээлгэх хариуцлага гэсэн үндсэн 3 бүлэг, 18 заалттай боловсруулагдсан.

Барилга байгууламжийг шинээр ашиглалтад орох үед өмчлөгч, эзэмшигч нь барилга байгууламжийн хувийн хэргийг нээж, түүнд холбогдох хавсралт материалууд болон барилга байгууламжийн баримт бичгийг бүрдүүлэн хөтөлж, барилга байгууламжийн эдэлгээний хугацаанд түүнд өргөтгөл, шинэчлэл, их засвар, үзлэг, шалгалт хийсэн, зориулалтыг өөрчилсөн, эвдрэл, гэмтэл, согог гарсан, сервитут, хамгаалалтын горим тогтоосон, буулгасан тохиолдолд энэ талаар хувийн хэрэгт бичиж, холбогдох материалыг бүрдүүлж хадгална.

Хувийн хэрэг хөтлөгдөж байгаагүй хуучин барилга байгууламжид тусгай зөвшөөрөл бүхий зураг төслийн байгууллагатай гэрээ байгуулан холбогдох үзүүлэлтийг дахин тооцуулах, мэргэжлийн дүгнэлт гаргуулах, хэмжилтийн зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгүүлж, түүнийг үндэслэн хувийн хэргийг өмчлөгч, эзэмшигч нь нөхөн хөтөлж, баяжуулалт хийнэ.

Барилга байгууламжийн хувийн хэргийг доорх бүрдэл хэсгээр хөтлөх бөгөөд түүнд заасан холбогдох үзүүлэлтүүдийг барилга байгууламж нэг бүрд тодорхойлж тэмдэглэнэ. Үүнд:

1. Барилга байгууламжийн үндсэн мэдээлэл
2. Барилга байгууламжид хийсэн үзлэг, шалгалтын тэмдэглэл
3. Барилга байгууламжид хийсэн их засвар, өргөтгөл, шинэчлэлийн талаарх тэмдэглэл
4. Барилга байгууламжийн дахин үнэлгээ
5. Ашиглалтын явцад гарсан эвдрэл, гэмтэл, согогийн тухай тэмдэглэл
6. Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөлтийн байдал
7. Барилга байгууламжийн холбогдолтой баримт бичгийн жагсаалт

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 71 дүгээр тушаалаар баталсан “Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам”, “Барилга байгууламжийн хувийн хэрэг”-ийг “Барилгын тухай” шинэ хуульд нийцүүлэн хянаж шинэчлэн боловсруулахдаа барилга байгууламжид хамгаалалтын горим, сервитут тогтоосон, барилгын ажлын явцад материал хийц, бүтээцийг зураг төсөл зохиогчийн зөвшөөрөлтэйгээр өөрчилсөн, барилга байгууламжийн төвөгшлийн зэрэг тогтоосон, ашиглалтын гэрчилгээ олгосон, чанар аюулгүй байдлын түвшингээр паспортжуулсан, зүгшрүүлэх, тохируулах, хэвийн

ашиглалтын болон эдэлгээний хугацааг тогтоосон байдал, эдэлгээний хугацаа дууссан үед цаашид ашиглахаар шийдвэрлэсэнтэй холбоотой мэдээлэл, шийдвэрийн талаар хувийн хэрэгт тодорхой бичиж тэмдэглэхээр шинээр нэмж тусгасан. Үүнтэй холбогдуулан дараахь баримт бичгийг шинээр бүрдүүлэн барилга байгууламжийн хувийн хэрэгт хадгалахаар жагсаалтад нэмж оруулсан.

- Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар хувь
- Барилга барих газрын нэгж талбарын кадастрын зураг
- Барилгын ажлын талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөл
- Гүйцэтгэлийн зураг төсөл
- Байр зүйн дэвсгэр зураг
- Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан акт болон зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт, захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлтийн хуулбар хувь
- Барилга байгууламжид хамгаалалтын горим тогтоосон шийдвэрийн хуулбар хувь
- Барилга байгууламжийн төвөгшлийн ангилал/зэрэг/ тогтоосон, паспортжуулсан, ашиглалтын гэрчилгээ олгосон шийдвэрийн хувь
- Барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээц, материалд оруулсан өөрчлөлт, даацын бат бэхийг лабораторийн шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулсан баталгаажуулалтын хуулбар хувь
- Барилга байгууламжид сервитут тогтоосон шийдвэрийн хуулбар хувь
- Эдэлгээний хугацаа дуусахад цаашид ашиглахаар шийдсэн шийдвэрийн хувь
- Барилга байгууламжийг албадан буулгах шийдвэрийн хувь

“Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам”, “Барилга байгууламжийн хувийн хэрэг”-ийг шинэчилснээр эзэмшигч, өмчлөгч, худалдан авагч, түрээслэгч, үнэлгээчин, шинжээч, хууль хяналтын байгууллагыг тухайн барилга байгууламжийн талаарх мэдээллээр хангах, ашиглалтын явцад барилга байгууламжид эвдрэл гэмтэл учрах, нурах тохиолдолд барилгын ажил гүйцэтгэгч, захиалагч, зураг төсөл зохиогч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутайг нь тогтоож хариуцлага хүлээлгэх талаар холбогдох мэдээллийг хувийн хэргээс ашиглах боломж бүрдэх юм. “Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам”, “Барилга байгууламжийн хувийн хэрэг”-ийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, санал авахаар БХБЯамны вэб сайтад нийтлүүлсэн болно.